



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Үнэт цаасны өмчлөх эрхийг
шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Арилжаа импекс” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Арилжаа импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигч Д.Батнасангийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс дахь 49,706 /дөчин есөн мянга долоон зуун зургаа/, С.Балдандорж данс дахь 155,676 / нэг зуун тавин таван мянга зургаан зуун далан зургаа/ ширхэг “Арилжаа импекс” ХК-ийн энгийн хувьцааг “Улаанбаатар хивс” ХК-д тус тус шилжүүлэхээр гаргасан хүсэлтийн дагуу өмчлөх эрхийг тогтоосон нөхцөл, шаардлага, нотлох баримтын бүрдэл, үйлчилгээний хөлсийг авч холбогдох журмын дагуу өмчлөх эрхийг шилжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

2. “Арилжаа импекс” ХК-ийн хяналтын багцыг өмчлөх болсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Улаанбаатар хивс” ХК /З.Эрдэнэ/-д үүрэг болгосугай:


1/ Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компанийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, компанийн удирдлагыг сонгох, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, компанийн цаашдын үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж, хурлын материалыг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлэх;


2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

108034

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасгай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



The stamp is rectangular with a double-line border. Inside, there is a central emblem featuring a traditional Mongolian pattern. The text 'МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖАЛГА' is written vertically on the left side, and 'МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖАЛГА' is written vertically on the right side. The word 'МОНГОЛ' is written horizontally across the top of the emblem.